



**ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН  
ТУШААЛ**

2017 оны 01 сарын 31 өдөр

Дугаар А/07

Улаанбаатар хот

Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай

Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6, 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалт, “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн дүрмийн 14.6.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хөдөө аж ахуйн Бирж” ХХК-ийн 2017 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг Хавсралтын ёсоор баталсугай.
2. Төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, дотоод аудитын хэлтэс /Г.Чинбат/, компанийн эрх бүхий албан тушаалтын Г.Туяа нарт үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.БААТАР

"ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ" ХХК-ИЙН 2017 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ  
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ



№	Хийх ажлын агуулга	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах нэгж, албан тушаалтан
1.	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаарх мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах	1.1 Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчлах /мэдээллийн самбар, цахим хуудас, теле сурталчилгаа, яриа таниулга, сонсгол, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг, хэвлэмэл материал г.м/	Жилдээ	Захиргаа, дотоод аудитын хэлтэс, ЭБАТ
2.	Үйл ажиллагааны орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх, цахим хуудсанд байршуулах	2.1 Тухайн жилийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтод түвшин, нэмэлт өөрчлөлт	Жилдээ	Захиргаа, дотоод аудитын хэлтэс
		2.2 Жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт	4 дүгээр сарын 25-ны дотор	Захиргаа, дотоод аудитын хэлтэс
		2.3 Хагас жилийн санхүүгийн тайлан	8 дугаар сарын 15-ны дотор	Захиргаа, дотоод аудитын хэлтэс
		2.4 Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	7 дугаар сарын 1-ний дотор	Захиргаа, дотоод аудитын хэлтэс
3.	Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах	3.1 Биржээс олгож буй зөвшөөрөл /суудлын эрх, итгэмжлэгдсэн этгээдийн үйл ажиллагаа явуулах эрх зэрэг/ эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсанд байршуулах	Жилдээ	Стратеги, судалгаа хөгжлийн хэлтэс Төлбөр тооцоо, ложистикийн хэлтэс
		3.2 Аливаа үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотойгоор бусад байгууллагаас олгосон зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, эрх г.м бусад үйл ажиллагаа эрхлэх/, түүний талаарх мэдээллийг цахим хуудсанд байршуулах	Жилдээ	
4.	Удирдлагын шийдвэр болон хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах	4.1 Удирдлагын шийдвэр /Хувь нийлүүлэгчдийн хурлын болон ТУЗ-ийн тогтоол/-ийн ил тод, нээлттэй байдлыг хангах нөхцөл, боломжийг бүрдүүлсэн байх /цахим хуудсаар/ 4.2 ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал болон эрх бүхий албан тушаалтнуудын товч танилцуулгыг цахим хуудсанд байршуулах	2 дугаар сард	Захиргаа, дотоод аудитын хэлтэс
5.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг	5.1 Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам /тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт/, тендерийн үр дүнгийн талаар цахим хуудсанд байршуулах	Тухай бүр	Стратеги, судалгаа хөгжлийн хэлтэс

	хангах, түүнтэй танилцах боломжоор хангах	5.2 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтын хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг цахим хуудсанд байршуулах	Тухай бүр	Төлбөр тооцоо, ложистикийн хэлтэс
		5.3 Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг цахим хуудсандаа байршуулах	Жилдээ	Захиргаа, дотоод аудитын хэлтэс
6.	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах	6.1 Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах ЭБАТ-ын гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолт болон ажил үүргийн хуваарьт тусгах	1 дүгээр сард	Захиргаа, дотоод аудитын хэлтэс
		6.2 Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтад хамрагдсан байх	Тухай бүр	ЭБАТ
		6.3 Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх /хүнд суртал, чирээдлийг багасгах, сөрөг үзэгдлийг хаах, ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг хянах, мэдээгдэл гаргах, албан хаагчийн ажлын байрыг сэлгүүлэх зэрэг үр дүнтэй арга хэмжээг хэрхэн зохион байгуулсан г.м/	Жилдээ	ЭБАТ
		Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх	Жилдээ	ЭБАТ
7.	Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх	7.1 Компанийн Ёс зүйн хороог шинээр байгуулж, дүрмийг шинээр боловсруулж батлуулах. Нийт ажилтнуудад танилцуулах	2 дугаар сард	Захиргаа, дотоод аудитын хэлтэс
		7.2 Зөрчил илэрсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэж, хамт олонд мэдээлсэн байх	Тухай бүр	Ёс зүйн хороо
8.	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах	8.1 Засгийн газар, яамд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэр	Тухай бүр	Захиргаа, дотоод аудитын хэлтэс
		8.2 Нэмэлт өөрчлөлт орсон компанийн дотоодод мөрдөгдөх дүрэм, журам, заавар	Тухай бүр	Захиргаа, дотоод аудитын хэлтэс
9.	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт	9.1 Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга /уриа, уриалга, мэдээгдэл, амлалт г.м/-д нэгдсэн байдал	Жилдээ	ЭБАТ
		9.2 Авлигын эсрэг арга хэмжээнд зориулан тусгайлан хөрөнгө гаргасан эсэх /зарцуулалт/	Жилдээ	ЭБАТ
		9.3 Албан тушаалтан, албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ /шударга ёс, ёс зүй сонирхлын зөрчлийн талаарх сургалт, хэлэлцүүлэг, ярилцлага, өдөрлөг, зөвлөмж өгөх г.м/-г авах	Жилдээ	Захиргаа, дотоод аудитын хэлтэс